



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/32/

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.3, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2.6, Засгийн газрын 2017 оны “Захиалагчийн дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг-2024” А/259 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн их засварын хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засвар төсөл арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240101117/ дугаартай 186,074,372 (Нэг зуун наян зургаан сая далан дөрвөн мянга гурван зуун далан хоёр) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Өнөших Трейд” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанитай гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Өнөших Трейд” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, зөвлөх үйлчилгээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөх үйлчилгээний ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх, зураг төслийг хүлээн авах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

О.Насанжаргал

(Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн Санхүү,
эдийн засаг, аж ахуйн албаны дарга)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан
ахлах мэргэжилтэн)
 (“Өнөших Трейд” ХХК-ийн захирал)

Б.Гүнбат

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

О.Дагиймаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл
мэндийн бодлого, үйл ажиллагааг зохион
байгуулах мэргэжилтэн)

d/A4

6712011010

3. Аймгийн их засварын хөрөнгө оруулалтын санхүүжилтээр батлагдсан Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засвар төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатанд хийх захиалагчийн хяналтыг "Өнөших Трейд" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх, уг гэрээг дүгнэх, ил далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг тус тус баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тайлан барилга байгууламжийн ажлын гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр архивлан тус газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засварын шинэчлэлтийн ажлыг нийлүүлэх гүйцэтгэгч сонгоход хэрэгжүүлэх шаардлагатай зардлыг гэрээний дагуу "Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ-т Нэгдсэн эмнэлгийн дээврийн их засвар төсөл арга хэмжээний ажлыг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт шилжүүлэхийг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т тус тус зөвшөөрсүгэй

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР